

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ ХОРИНГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2016 оны наймдугаар сарын 11-ний 14 цаг 02 минутад эхэлж, 15 цаг 20 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 18 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Зарим яамдын Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд</li><li>- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд</li><li>- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд</li><li>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд</li><li>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд</li><li>- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд</li></ul>	<p>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатын 2016 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн ХЭГ/1285 тоот албан бичгээр Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд тус тус томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2016 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн, ажлын 21 хоног Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
2	<p>Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Орхон аймгийн Засаг дарга Д.Батлутын 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 1/2261 тоот албан бичгээр Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, ажлын байранд тавигдсан туршлагын шаардлага нь Төрийн албаны тухай</p>

		хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5 заалтад нийцэхгүй байна гэж үзээд буцаахаар шийдвэрлэв.
3	Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүдийн ажил, үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Улсын Их Хурлын 2016 оны 84,85 дугаар тогтоолыг тус тус үндэслэн:</p> <p>1. “Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 15 дугаар тогтоолын хавсралтын “Гурав”-т “Д.Даваа-Очирын” гэснийг “Б.Баатарзоригийн” гэж, мөн хавсралтын “Дөрөв”-т “Т.Хадхүүгийн” гэснийг “С.Цэдэндамбын” гэж тус тус өөрчлөх</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарьт заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг орон тооны гишүүн Б.Баатарзориг, С.Цэдэндамба нарт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА